



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226 3168, Факс: (976-11) 312 315,
E-mail: info@mrt.gov.mn, http://www.mrt.gov.mn

2016.04.14 № 08/1552

танай _____ -ны № _____ -т


**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.НЯМДАВАА ТАНАА**

Зам, тээврийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 94 дүгээр тушаалаар батлагдсан "Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны" хөтөлбөрийг хүргүүллээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг 2016 оны 05 дугаар сарын 16-ны дотор боловсруулж батлуулахаар ирүүлнэ үү.

Хавсралт 3 хуудастай.

АГААРЫН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ **С.МӨНХНАСАН**





МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

“Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны
хөтөлбөр” батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24.2 дугаар заалт, Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг 2016 оны 2-р улиралд багтаан боловсруулж, батлуулахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Г.Нямдаваа/-т даалгасугай.

3.Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Г.Нямдаваа/-т, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /С.Мөнхнасан/-т үүрэг болгосугай.

САЙД



М.ЗОРИГТ

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Нэг. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үзэл баримтлал, ойлголт

Иргэний нисэхийн салбарт шинэ техник технологи, шинэ агаарын хөлгийн хэв маяг нэвтрэхийн зэрэгцээ тэдгээрийн аюулгүй, найдвартай үйл ажиллагааг хангах нь онцгой чухал асуудал болон тавигддаг.

Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 3.1.13-т “Нисэхийн аюулгүй ажиллагаа” гэж нислэгийн үйл ажиллагаа болон түүнд хамаарах бусад үйл ажиллагааг хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөд хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх нөхцөл байдал болон чадвар гэж тодорхойлсон байдаг. Энэ нь агаарын хөлөгт хамааралтай, эсхүл түүний үйл ажиллагаанд шууд дэмжлэг үзүүлдэг нисэхийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулах болон хянах байдлаар илэрхийлэгдэнэ.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн Хавсралтууд 1, 6, 8, 11, 13, 14-ийн заалтуудыг нэгтгэсэн “Аюулгүй ажиллагааны удирдлага” Хавсралт 19-ийг 2013 онд батласан бөгөөд гишүүн улс орнууддаа аюулгүй ажиллагааны удирдлагын оновчтой тогтолцоог Хавсралт 19-ын стандартын дагуу нэвтрүүлэн ажиллах шаардлага тавьдаг.

Энэхүү шаардлагыг хэрэгжүүлэх, ажлын хүрээнд Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хангалт, сайжруулалтыг энэхүү Үндэсний хөтөлбөрт дараах байдлаар томъёолж байна. Үүнд:

- Иргэний нисэхийн хууль эрх зүйн орчин болон үүрэг хариуцлага;
- Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо;
- Мэдээлэл, дүн шинжилгээнд суурилсан Аюулгүй ажиллагааны баталгаажилт;
- Аюулгүй ажиллагааны талаарх харилцаа холбоо, боловсрол, сургалт дадлага.

Хоёр. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл

Монгол Улс 1989 оны 09 дүгээр сард нэгдэн орсон Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн “Аюулгүй ажиллагааны удирдлага” Хавсралт 19-ын дагуу иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны удирдлага зохицуулалт хийх хөтөлбөртэй байх үүрэг хүлээдэг. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт баримтлах бодлого”-ын 4 дүгээр бүлгийн 4.1-т “Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжийн хүрээнд боловсруулсан, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцсэн иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөртэй байх” тухай заасан.

Дээрхи шаардлагуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллагаас гаргасан загвар хөтөлбөрийг үндэслэл болгон “Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр” /цаашид “Хөтөлбөр” гэх/-ийг боловсруулав. Энэхүү хөтөлбөр нь иргэний нисэхийн салбарын хөгжлийн явцад өөрчлөгдөж, сайжирч байх болно.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын иргэний нисэхийн салбарын Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааг хангахад голлох үүрэг хүлээн оролцдог төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын хоорондын харилцан ажиллагааг зохицуулах, агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дөрөв. Хөтөлбөрийг зорилтууд

Иргэний нисэхийн тогтолцоог бүрдүүлж, дээрх зорилгыг хэрэгжүүлэхдээ "Аюулгүй, найдвартай, үр ашигтай ба тогтвортой агаарын тээврийн системийг бий болгох" гэсэн иргэний нисэхийн салбарын үндсэн зорилго болон Монгол Улс Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенци, түүний хавсралтуудаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг чухалчилна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зорилтуудыг удирдлага болгоно. Үүнд:

Зорилт 1: Олон улсын иргэний нисэхийн байгуулага (ICAO)-аас зөвлөмж болгосон Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны түвшин (ALoSP)-г хангах бодлого, зорилтыг хэрэгжүүлэх;

Зорилт 2: Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх;

Зорилт 3: Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны баталгаажуулалтыг хангах, хэрэгжүүлэх;

Зорилт 4: Аюулгүй ажиллагааны талаар танин мэдүүлэх, мэдлэгийг түгээх, мэргэшүүлэх үйл ажиллагааг сайжруулах.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

5.1 Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжүүдийг удиртгал болгох;

5.2 Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, агаарын тээвэрлэгчид болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлах;

5.3 Салбар дундын хамтын ажиллагаанд тулгуурлан иргэний нисэхийн аюулгүй ажиллагаанд эрсдэл үүсгэх хүчин зүйлсийг бууруулах;

5.4 Хөтөлбөр болон Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, сайжруулах үйл ажиллагаанд иргэний нисэхийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх;

5.5 Осол, ноцтой зөрчил, зөрчлийн тоог бууруулах;

5.6 Агаарын тээврээр үйлчлүүлэгчдэд учруулах хохирлыг багасгах;

5.7 Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны мэдээ, мэдээллийг өгөх, цуглуулах, үнэн бодит байдлыг тогтоох, баримтжуулах, мэдээллийн хүртээмж ашиглалтыг сайжруулах;

5.8 Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийг олон улсын хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хангуулах;

5.9 Осол, ноцтой зөрчил, зөрчил болон аюулгүй ажиллагааны мэдээ мэдээлэл, түүний дүн шинжилгээнд тулгуурлан иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны эрсдлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх.

Зургаа. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага нь Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага байна.

6.2 Хөтөлбөрийг Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц, олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн 4 зорилт, 31 бүрэлдэхүүн хэсгийн дагуу хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

6.2.1 Зорилт 1: “Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-аас зөвлөмж болгосон Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны түвшин (ALoSP)-г хангах бодлого, зорилтыг хэрэгжүүлэх” –ийн хүрээнд:

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1/ Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаанд “Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенци, түүний Хавсралтуудыг мөрдлөгө болгон ажиллах ба уг конвенци, түүний хавсралтуудад орох нэмэлт зохицуулалтуудыг үндэсний эрх зүйн бичиг баримтуудад тухай бүр тусган сайжруулалт хийх;

2/ Иргэний нисэхийн салбарт шинэ техник технологи, шинэ агаарын хөлгийн хэв маяг нэвтрүүлэхтэй холбоотойгоор тэдгээрийн аюулгүй, найдвартай үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлийн зохицуулалтуудыг Иргэний нисэхийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, иргэний нисэхийн багц дүрмүүд болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд тухай бүр тусган сайжруулалт хийх;

3/ Нислэг-техникийн осол, зөрчил болон нислэг-техникийн осол, зөрчлийн урьдчилсан нөхцөл үүссэн тохиолдлыг шинжлэн шалгах, ангилах, бүртгэх, осол зөрчлийн тайлан, зөвлөмж гаргах, веб сайтаар олон нийтэд мэдээлэх зэрэг үйл ажиллагааг олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөмж, загвар дүрмийн дагуу болгон шинэчлэн сайжруулах;

4/ Аюулгүй ажиллагаанд оролцогч бүхий л талуудын уялдаа холбоог сайжруулах, осол, зөрчлийн дүгнэлтийг үндэслэсэн осол, зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг тогтолцоог бий болгох;

5/ иргэний нисэхийн бүх шатны байгууллагууд, ажилтнуудын хүрээнд аюулгүй ажиллагааны удирдлагыг дэс дараатай хэрэгжүүлж, аюулгүй ажиллагааны зөвшөөрөгдөх түвшин (ALoSP)-г хангах зорилтыг аюулгүй ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлтөнд тусган хэрэгжүүлэх;

6/ Аюулгүй ажиллагааны удирдлагын зохицуулалт нь бодитой, тэнцвэртэй, үндэслэл бүхий байх, эрсдэл дээр суурилсан байх зарчмыг хэрэгжүүлэх;

7/ Албадлагын арга хэмжээний бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх.

Хүрэх үр дүн:

1/ Иргэний нисэхийн тухай хуульд иргэний нисэхийн аюулгүй ажиллагааг хангахад шаардагдах холбогдох зохицуулалтууд орсон байна.

2/ Иргэний нисэхийн багц дүрмүүдэд аюулгүй ажиллагааг хангахад шаардагдах холбогдох зохицуулалтууд орсон байна.

3/ Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагааны зохицуулалтын баримт бичгүүдэд иргэний нисэхийн аюулгүй ажиллагааг хангахад шаардагдах холбогдох зохицуулалтууд орсон байна.

4/ Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаанд голлох үүрэг, хариуцлага бүхий албан тушаалтан, байгууллагын хүлээх үүрэг хариуцлага тодорхой болж, харилцан уялдаа холбоо сайжирсан байна.

5/ Осол, ноцтой зөрчил, зөрчлийн судалгаа, шинжлэн шалгах эрх зүйн орчин боловсронгуй болж, эрх зүйн баримт бичгүүдэд холбогдох зохицуулалтууд орсон байна.

6/ Албадлагын арга хэмжээний бодлогыг тодорхойлж, эрх зүйн баримт бичгүүдэд холбогдох зохицуулалтууд орсон байна.

7/ Иргэний нисэхэд баримтлах улсын аюулгүй ажиллагааны хүлээн зөвшөөрөгдөх түвшин тодорхойлогдсон байна.

6.2.2 Зорилт 2: “Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх”-ийн хүрээнд:

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1/ Агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын аюулгүй ажиллагаанд эрсдлийн менежментэд суурилсан удирдлагын тогтолцоог үе шаттайгаар, тодорхой төлөвлөлттэйгээр нэвтрүүлэх;

2/ Аюул, эрсдлийг тодорхойлох, аюулгүй ажиллагааны эрсдлийн удирдлагыг гүйцэтгэх нэгдсэн аргачлал, зөвлөмжийг боловсруулах;

3/ Аюулыг тодорхойлохдоо гарах магадлал болон учруулах аюулын түвшингээр нь ангилах;

4/ Эрсдлийг үнэлэх шалгуур, эрсдлийн зөвшөөрөгдөх хэмжээг тодорхойлох аргачлалыг боловсруулах;

5/ Засаж залруулах, урьчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг аюул ослын онцгой байдал, урьдчилан тооцоогүй гэнэтийн аюул үүссэн давтамжийг харгалзан боловсруулж, бэлэн байдлыг хангах, үр дүнг нь дүгнэдэг байх тогтолцоог бий болгох;

6/ Иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллагууд болон агаарын тээвэрлэгчид нь үйл ажиллагааны чиглэл тус бүрээр эрсдлийн түвшингээ тодорхойлох;

7/ Аюулгүй ажиллагааны эрсдлийг арилгах нөөц, боломжтой байх;

8/ Аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийн хэмжигдэхүйц үзүүлэлтүүдийг олон улсын стандартын дагуу тодорхойлох;

9/ Агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллагууд нь аюулгүй ажиллагаандаа гарч буй хүндрэл, осол аюул, эсхүл онцгой нөхцөл байдал үүссэнийг заавал мэдээлэх, сайн дураараа мэдээлэх, мэдээлэгчид аливаа сахилгын болон захиргааны хариуцлага хүлээлгэхгүй байх тогтолцоог бүрдүүлэх.

Хүрэх үр дүн:

1/ Агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоонд эрсдлийн менежментийг нэвтрүүлсэн байна.

2/ Агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллага нь аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийн үзүүлэлт, аюулгүй ажиллагааны хүрэх зорилтот түвшнээ тодорхойлж, тэдгээрийг үнэлж хэмжих тогтолцоо бүрдсэн байна.

3/ Агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын аюулгүй ажиллагааны эрсдлийг үнэлэх шалгуур, эрсдлийн зөвшөөрөгдөх хэмжээг тогтоож, эрсдлийн түвшингээ тодорхойлон эрсдлийг арилгах нөөцтэй болсон байна.

4/ Агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоонд тогтмол үечлэлтэйгээр үнэлэлт, дүгнэлт өгөх арга, аргачлал боловсруулагдан хэрэгжсэн байна.

5/ Аюулгүй ажиллагаандаа гарч буй хүндрэл, осол аюул, эсхүл онцгой нөхцөл байдал үүссэнийг заавал мэдээлэх, сайн дураараа мэдээлэх тогтолцоог бий болгосон байна.

6.2.3 Зорилт 3: “Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны баталгаажуулалтыг хангах, хэрэгжүүлэх”-ийн хүрээнд:

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1/ Аюулгүй ажиллагааны талаархи хууль, эрх зүй, зохицуулалтын баримт бичгүүдийг зохистой түвшинд байлгаж, хэрэгжилтийг хангуулах;

2/ Аюулгүй ажиллагааны хяналт, мониторингийн тогтолцоонд урьдчилан харах (proactive) дадал, туршлагыг хөгжүүлэх;

3/ Аюулгүй ажиллагааны мэргэжлийн заавар, арга хэрэгслүүд болон онц чухал шаардлагатай мэдээллээр хангах;

4/ Аюулгүй ажиллагааны мэдээллийг цуглуулах, ашиглах, дүн шинжилгээ хийх, харилцан солилцох ажиллагааг оновчтой зохион байгуулах, цахим мэдээллийн систем нэвтрүүлэх;

5/ Мэргэжлийн ажилтнуудыг мэргэшүүлэн сургах тогтолцоог боловсронгуй болгох;

6/ Үнэмлэхжүүлэлт, гэрчилгээжүүлэлтэд тавигдах шаардлагыг өндөржүүлэх;

7/ Аюулгүй ажиллагааны зөвшөөрөгдөх түвшин (ALoSP)-ий бүрдэл хэсгүүд болох аюулгүй ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд, үр дүнгийн шалгуурууд, тавигдах

шаардлагууд, онцгой нөхцөл байдлын аюулгүй ажиллагааны журмыг шинэчлэн тогтоож, мөрдүүлэх;

8/ Агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын аюулгүй ажиллагааны удирдлага, эрсдэлд суурилсан хяналт, мониторингийн тогтолцоог үнэлэх.

Хүрэх үр дүн:

1/ Иргэний нисэхийн эрх зүйн зохицуулалтын баримт бичгүүдийн шаардлагыг агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллага бүрэн хангаж байгаа эсэхэд хяналт мониторинг хийх хөтөлбөртэй болсон байна.

2/ Аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалттай холбоотой баримт бичгүүдэд холбогдох зохицуулалтууд тусгагдсан байна.

3/ Аюулгүй ажиллагааны мэдээллийг цуглуулах, ашиглах, дүн шинжилгээ хийх, харилцан солилцох ажиллагаанд цахим систем нэвтрүүлсэн байна.

4/ Аюулгүй ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд, үр дүнгийн шалгуурууд, тавигдах шаардлагууд, онцгой нөхцөл байдлын аюулгүй ажиллагааны журмыг шинэчлэн тогтоосон байна.

5/ Үнэмлэхжүүлэлт, гэрчилгээжүүлэлтэд тавигдах шаардлагыг аюулгүй ажиллагааны олон улсын стандартын дагуу шинэчилсэн байна.

6.2.4 Зорилт 4: “Аюулгүй ажиллагааны талаар танин мэдүүлэх, мэдлэгийг түгээх, мэргэшүүлэх үйл ажиллагааг сайжруулах”-ийн хүрээнд:

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1/ Олон улсын иргэний нисэхийн байгууллага(ICAO)-ын үйл ажиллагаанд идэвхитэй оролцогч байж, аюулгүй ажиллагааны чиглэлээр олон улсын дэвшилтэт туршлагыг нэвтрүүлэх;

2/ Аюулгүй ажиллагааны олон улсын стандартыг нэвтрүүлэх, мөрдүүлэх чиглэлээр сургалтын тусгайлсан хөтөлбөр боловсруулж, батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулах;

3/ Хувь хүний мэдлэг, ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх, ажлын байран дээрхи сургалт, дагалдуулан дадлагажуулах аргыг ашиглах;

4/ Аюулгүй ажиллагааны талаархи бодлого, эрх зүйн баримт бичгүүд, статистик тоо баримтууд, шинжлэн шалгасан тайлан, илтгэл, ном товхимол, зөвлөмж зэрэг холбогдох мэдээллийг солилцох, түгээх системийг хөгжүүлэх;

5/ Агаарын зайн цогц байдал, аюултай бүсэд нислэг үйлдэх зэрэг мэргэжлийн зөвлөмж, удирдамж, зааварыг багтаасан иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны гарын авлага, ном, товхимолыг хэлбэрээр үнэ төлбөргүй түгээх;

6/ Монгол Улсад агаарын зайд нислэг үйлдэхэд шаардлагатай бүх төрлийн мэдээллийг багтаасан Нисэхийн Мэдээллийн Эмхтгэл (AIP) –ийн аль нэг мэдээлэлд өөрчлөлт орох бүрд эмхэтгэлд өөрчлөлт оруулдаг байх;

7/ Аюулгүй ажиллагаа, түүний удирдлагын тогтолцооны танилцах сургалт, семинар, хэлэлцүүлэг, мэргэжлийн зөвлөлгөө өгөх үйл ажиллагааг агаарын тээвэрлэгч,

иргэний нисэхийн үйл ажиллагаанд оролцогч, ажлын уялдаа холбоог хангах шаардлагатай бусад этгээдийн дунд тогмол зохион байгуулах.

Хүрэх үр дүн:

1/ Олон улсын иргэний нисэхийн байгууллага(ИКАО)-ын үйл ажиллагаанд тогтмол, идэвхи санаачлагатай оролцдог тогтолцоог бий болгосон байна.

2/ Аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, улсын дэвшилтэт туршлагыг нэвтрүүлсэн байна.

3/ Тусгайлан батласан сургалтын хөтөлбөрийн дагуу аюулгүй ажиллагаа, эрсдлийн удирдлагын талаар тогтмол сургалт, сурталчилгааны ажил явуулдаг жишиг тогтсон байна.

4/ Ажлын байран дээр суралцах боломж, нөхцлийг бүрдүүлсэн дүрэм, журам, хөтөлбөртэй болсон байна.

5/ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллагуудыг тогтмол мэдээ мэдээллээр хангаж, аюулгүй ажиллагааны стандартаас гадна соёлыг нэвтрүүлэх талаар ажлууд зохион байгуулсан байна.

6/ Аюулгүй ажиллагаа, түүний удирдлагын тогтолцооны чиглэлээр хэлэлцдэг, мэдлэг мэдээлэл, ур чадвараа хуваалцдаг тогтолцоог нэвтрүүлсэн байна.

Долоо. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт

7.1 Хөтөлбөр болон Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх хугацаа нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гишүүн орнууддаа зөвлөмж болгосны дагуу тогтмол хэрэгжинэ.

7.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, зохион байгуулах байгууллага, эрх бүхий албан тушаалтан нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон түүний дарга байна.

7.3 Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг төсвийн дагуу захиран зарцуулах эрхтэй байна.

7.4 Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах баг, албан тушаалтныг томилно.

7.5 Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх үүргийн тодорхой хэсгийг Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дэх хэсгийг үндэслэн "Эрх үүрэг шилжүүлэх тухай гэрээ"–гээр холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно.

7.6 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага боловсруулан Иргэний нисэхийн асуудал хариуцсан сайдаар батлуулна.

7.7 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх баг, түүнийг хэрэгжүүлэгч албан тушаалтан нь Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийн хүлээн зөвшөөрөгдөх түвшин, аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийн үзүүлэлтийг

тодорхойлохын тулд агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоонд байнгын хяналт тавина.

7.8 Агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллагууд нь уг Хөтөлбөр болон Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн Хавсралт 19-ын дагуу Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн хэрэгжүүлж, тогтмол сайжруулна.

Найм. Хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт

8.1 Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүр өөрийн төсөвт тусган батлуулна.

8.2 Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.5 заалтын хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн хүрээнд иргэний нисэхийн үйлчилгээний орлогоос бүрдүүлж болно.

8.3 Агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх байгууллагууд нь Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг жил бүр өөрийн төсөвт тусган батлуулж, санхүүжүүлнэ.

Ес. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ

9.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, мониторинг, үнэлгээг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга хийж, Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хагас жил тутамд тайлагнана.

9.2 Хөтөлбөрийн гүйцэтгэлийн хяналт, үнэлгээтэй холбоогоор хөтөлбөрт орох нэмэлт өөрчлөлтийг хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах баг, албан тушаалтан гүйцэтгэнэ.

Арав. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны түвшинг илтгэх үзүүлэлтүүд болох улсын аюулгүй ажиллагааны хүлээн зөвшөөрөгдөх түвшин, аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийн үзүүлэлт болон аюулгүй ажиллагааны зорилтот түвшин зэрэг үзүүлэлтүүдийг тоон утгаар илэрхийлэх, тэдгээрт дүн шинжилгээ хийж эрсдэлийг удирдах боломжтой болно.

Хөтөлбөрийг үнэлэх үндсэн шалгуур нь иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 4 зорилт, 43 бүрэлдэхүүн хэсэг, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн болон Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлагад нийцсэн иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны түвшинг илтгэх үзүүлэлтүүдийн тоон утгаар илэрхийлэгдэнэ.